

“МОН-НАБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“МОН-НАБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 07 дугаар сарын 18 -ны өдөр Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4- р хороо ЗГ-н 11-р байр 1206 тоотод болов. Хурал 14.00 цагаас эхлэж Р.Зоригт даргалан явуулав.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигч:

- | | |
|-----------------|----------------------------------|
| - Т. Бадамжунай | / 62400 ширхэг хувьцаа эзэмшигч/ |
| - Р.Зоригт | / 37497 ширхэг хувьцаа эзэмшигч/ |
| - Ю.Натарпүрэв | / 170 ширхэг хувьцаа эзэмшигч / |
| - Л.Пүрэв | / 137 ширхэг хувьцаа эзэмшигч/ |
| - З.Бүдсүрэн | / 137 ширхэг хувьцаа эзэмшигч/ |

нар тус тус хүрэлцэн ирж, ирц 81.7 хувьтай байв.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцсэн болно. Үүнд:

- ТУЗ-н ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн ТУЗ-н ердийн болон хараат бус гишүүдийг сонгох талаар Р.Зоригт танилцуулж, дараах нэмэлт тайлбарыг хийв.

Хувьцаа эзэмшигчид 2019-04-05 нд ээлжит хурлаа хийсэн. Гэвч Санхүүгийн Зохицуулах хорооноос хурлын материалыг хянан ТУЗ –н гишүүдийг сонгох ээлжит бус хурал зарлан хуралдуулах даалгавар ирүүлсэнийг дагуу ээлжит бус хурал зарлан ТУЗ-н гишүүдийг сонгох асуудлыг энэхүү хурлаар хэлэлцэж батлана.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан санал шүүмжлэл дараах байдлаар өрнөв. Үүнд:

Хувьцаа эзэмшигчид хэнийг нэр дэвшүүлж сонгох саналтай байгаагаа хэлнэ үү.

Р.Зоригт: За би хувьцаа эзэмшигчийн хувьд дараах хүмүүсийг нэр дэвшүүлж байна гээд хүн тус бүрийн талаар дэлгэрэнгүй танилцуулав .

ТУЗ-н ердийн гишүүнд

1. Т.Бадамжунай
2. Р.Зоригт
3. Р. Алтанцэцэг
4. Ш.Оюун-Эрдэнэ
5. Д.Пүрэвээ

6. Л.Мөнхтуяа

ТУЗ-ийн хараат бус гишүүнд

1. Л.Амарсайхан
2. Г.Төгөлдөр
3. Д.Болорцэцэг

Л.Пүрэв: Миний хувьд ТУЗ- н зарим гишүүнд өөр хүмүүс сонгох саналтай ирсэн юм . Гэвч тэр хүмүүс хуралдаа ирсэнгүй тиймээс дээрхи нэр дэвшүүлсэн хүмүүсийг дэмжих саналтай байна


З.Бүдсүрэн: Би бас санал нэгтэй байна . Энэ нэр дэвшсэн хүмүүс хуучин гишүүд байна. Тиймээс ажлаа мэддэг хүмүүсийг сонгох нь зүйтэй гэж бодож байна.

Ю.Натарпүрэв: Шинээр сонгогдох гишүүд сайн ажилмаар байна шүү.Тэгээд эдгээр нэр дэвшсэн хүмүүсийг сонгох саналтай байна.

Хурлын дарга Р.Зоригт нэр дэвшиж байгаа хүмүүсийг сонгохдоо санал хураалтын кумулятив аргыг хэрэглэх тухай хувьцаа эзэмшигчдэд дэлгэрэнгүй тайлбарлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 16.00 цагт дуусав.

ХУРЛЫН ДАРГА
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Р.Зоригт

Д.Болорцэцэг

Р.Зоригт
Д.Болорцэцэг